

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн аудитын тайлан

УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ /ГАГ-2019/01-ГА/



Төсөл, арга хэмжээний төлөвлөлтөөс шалтгаалж хөрөнгө оруулалтын үр өгөөж буурч байна.

Чойбалсан хот

2019 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын
алба

Дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Б.Болортуул
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584204

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа,

Аудитор
Я.Зориг
С.Энхбаатар
Утас: 70584207

2019 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207, 70584204
дугаарын утас болон
dornod@audit.gov.mn
цахим хаягаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р байр,
2 давхар 04 тоот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. Хууль, журамд заасан шаардлагыг төсөл, арга хэмжээ төсөвт тусгагдан байна.

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд төлөвлөсөн байна.

1.2. Хууль, журамд заасан шаардлагыг хангаж арга хэмжээ төсөвт тусгагдан батлагдаж байгаа.

II Бүлэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хийгдээгүй байна.

2.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил журмын дагуу зохион байгуулагдсан байна.

2.2. Гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж тохиолдлууд гарсан байна.

Б.3. Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хийж байна.

2.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх ирсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хийгдээгүй байна.

III Бүлэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

3.1. Тухайн жилд хүрэх зорилтот түвшин хангагдаагүй байна.

3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх бодитой тооцож төлөвлөөгүй байна.

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН

ЗӨВЛӨМЖ

ТУШААЛ

АЛБАН ШААРДЛАГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГ	Засгийн газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗД	Засаг дарга
ГХБХБГ	Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
ЗТБХБС	Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХО	Хөрөнгө оруулалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг МУЕА-ын орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/03 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна уу?
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцсон байна уу?

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумдын ЗДТГ хамрагдлаа.

Үндсэн мэдээлэл:

Дорнод аймагт 2018 онд Монгол Улсын төсвийн тухай хуулиар батлагдсан 3,3 тэрбум төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирсэн байна.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ,

- худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
 - Газрын тухай хууль
 - Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам"
 - Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"
 - Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа:

Аудитын талбарын ажлыг 02 дугаар сарын 28-ны өдрөөс эхлүүлэн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд 04 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлээ.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, түүнд өгсөн тайлбар гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дэд зорилтын дагуу бичлээ. Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж санал авсан бөгөөд тайлангийн эцсийн хувилбарыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажууллаа.

I Бүлэг. Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээ төсөвт тусгагдан батлагдаж байна.

A.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн байна.

Улсын төсвөөс Дорнод аймагт эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээнүүд нь 100.0 хувь нийгмийн салбарт буюу боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэхээр төлөвлөгдсөн байна.

Хөрөнгө оруулалтын нийт 10 төсөл, арга хэмжээ нь улсын болон салбарын хөрөнгө оруулалтын бодлого, МУ-н тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, МУ-н мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний цогц бодлого баримт бичиг, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдаж, батлагдсан байна.

Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар ТЭЗ-аас хүргүүлсэн саналын эрэмбэлсэн жагсаалтад дараах 2 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна. Үүнд:

1. Хөгжимт драмын театрын барилгын гадна фасадын засварын ажил /30,0 сая төгрөг/
2. Биеийн тамир, спортын газарт спорт тоног төхөөрөмж худалдан авах /10,0 сая төгрөг/

A.2. Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээ төсөвт тусгагдан батлагдаж байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд нь нэр, байршил тодорхой, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулагдсан, магадлал хийгдсэн, зохих зөвшөөрлүүд олгогдсон нөхцөлд Төсвийн тухай хууль болон орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдах ёстой.

2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь дээрх шаардлагыг бүрэн хангахгүй байна. Үүнд:

1. Сургуулийн барилга засвар /Дорнод, Хэрлэн 1 дүгээр сургууль/ нэрээр хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтын XIII.1.1.2.2-т батлагдсан гүйцэтгэлийг үзэхэд барилгын биш халаалтын шугамын хэсэгчилсэн засвар хийгдсэн байна. Зураг төсөв нь халаалтын шугамын хэсэгчилсэн засвар хийхээр боловсруулагдаж батлагдсан байна.

2. Чулуунхороот сумын эрүүл мэндийн төвийн дээврийн засварын ажил “Чулуунхороот сумын эрүүл мэндийн төвийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрх” нэрээр хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтын XVIII.2.1.2.11-т батлагдсан байна.

Хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсвийг боловсруулж, батлуулсан хугацааг үзэхэд Төсвийн тухай хуулийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасантай нийцэхгүй байна. Үүнд:

Дорнод аймгийн хэмжээнд 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 10 төсөл, арга хэмжээ батлагдсанаас зураг төсөв шаардлагатай 9 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 7 төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь төсөв батлагдсанаас хойш буюу тайлант хугацаанд хийгдэж баталгаажсан байна.

Хүснэгт №1.

№	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зураг төсөв батлагдсан он
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум/	4 000,0	2018
2	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Дорнод, Хэрлэн сум, 1 дүгээр баг/	1 567,5	2018
3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 6 дугаар баг/	1 300,0	2018
4	Хөгжимт драмын театрын барилгын гадна фасадын засварын ажил /Дорнод, Хэрлэн сум/	30,0	2018
5	Сургуулийн засвар /Дорнод, Хэрлэн сум, Хан-Уул цогцолбор сургууль/	80,0	2018
6	Сургуулийн барилга засвар /Дорнод, Хэрлэн 1 дүгээр сургууль/	80,0	2018
7	Чулуунхороот сумын эрүүл мэндийн төвийн засварын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрх	100,0	2018
	Дүн	7157,5	

Төсөл, арга хэмжээнүүдийн зураг, төсөвт өөрчлөлт ороогүй байна.

Бусад зөвшөөрлийн хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум/, Цэцэрлэгийн барилга, 120 ор /Дорнод, Хэрлэн сум, 1 дүгээр баг/, Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 6 дугаар баг/ зэрэг төсөл, арга хэмжээнүүдэд газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдсон байна.

Харин Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын халаалтын нэгдсэн шугамд холбох ажил хийгдсэн ч шугамд холбох ажлын техникийн нөхцөл 1000 айлын орон сууцны дулааны шугам ашиглалтад ороогүйгээс шалтгаалан олгогдоогүй байгаа тул ашиглагдахгүй байна.

II Бүлэг. Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хууль, журмын дагуу зохион байгуулагдсан байна.

Дорнод аймагт 2018 онд салбарын сайд, холбогдох яамдаас 10 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргад болон Эрүүл мэндийн газарт эрх шилжүүлсэн байна. Үүнээс хууль, журмын дагуу хугацаанд нь эрх шилжүүлсэн 3, хугацаа хоцорч эрх шилжүүлсэн 7 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт №2. “Хугацаа хоцорч эрх шилжүүлсэн ТАХ”

Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжих дүн	Эрх шилжүүлэн авсан байгууллагын нэр	Огноо	Дугаар
XIII.4.1.18	Хөгжимт драмын театрын барилгын гадна фасадын засварын ажил /Дорнод, Хэрлэн сум/	30,0	АЗД	2018.04.27	1a/4025
XIII.4.1.19	Сургуулийн засвар /Дорнод, Хэрлэн сум, Хан-Уул цогцолбор сургууль/	80,0	АЗД	2018.04.27	1a/4025
XIII.4.1.20	Цэцэрлэгийн барилгын халаалтын нэгдсэн шугамд холбох /Дорнод, Хэрлэн сум, 2 дугаар цэцэрлэг/	70,0	АЗД	2018.04.27	1a/4025
XIII.1.1.2.2	Сургуулийн барилга засвар /Дорнод, Хэрлэн 1 дүгээр сургууль/	80,0	АЗД	2018.06.19	1a/6779
XVIII.2.1.2.10	Дорнод аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн төв корпусын засварын ажил	150,0	ЭМГ-ын дарга	2018.03.29	A/104
XIII.5.1.27	Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газарт спорт тоног төхөөрөмж худалдан авах	10,0	АЗД	2018.10.30	A/680
XVIII.2.1.2.11	Чулуунхороот сумын эрүүл мэндийн төвийн засварын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрх	100,0	ЭМГ-ын дарга	2018.03.29	A/104

Эрх шилжүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль /2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр/ батлагдсанаас хойш 60 хоногийн дотор холбогдох газруудад шилжүүлэх журмын заалттай. Гэтэл улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 8 төсөл, арга хэмжээг хугацаа хэтрүүлэн эрх шилжүүлсэн нь Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.11 дэх¹ заалтыг баримтлаагүй байна. Энэ байдал нь тендер оройтож зохион байгуулагдсанаас шалтгаалан худалдан авах ажиллагаа амжилтгүй болох, төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

ТЕЗ нь үнэлгээний хороог Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийг баримтлан зохион байгуулсан байна.

Тендерийн үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан “Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”-ийг баримтлан боловсруулсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2018 онд аймгийн Засаг даргад эрх нь шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим тендерээр зохион байгуулж, гүйцэтгэгчдийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулах үүднээс үнийн санал авах урилгыг зууны мэдээ сонинд нийтэлж, www.tender.gov.mn сайтад байршуулж нийтэд мэдээлсэн байна.

Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулсан байна.

¹ Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх.
Жич: 2018 оны 12-р сараас СС-ын 281 дүгээр тушаалыг мөрдөж эхэлсэн. Дээрх заалтын агуулга хэвээр хадгалагдсан байна.

Дүрслэл №1. "Худалдан авах ажиллагааны арга"



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 1 ажилд харьцуулалтын аргаар тендер зохион байгуулсан ч оролцогч ирээгүй шалтгаанаар шууд худалдан авалт хийх тухай шийдвэр гаргасан байна.

Хэрлэн сумын 1-р багт баригдах 120 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын тендерийг нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, ажил гүйцэтгэх чадвар, ажлын туршлага, бусад шалгуураар "Дорнын оч" ХХК-г шалгаруулжээ. Тендер шалгаруулалтын талаар "Сүхжин" ХХК-аас СЯ-нд гомдол гаргаж, үнэлгээний хорооноос тендерийн баримт бичигт дахин үнэлгээ хийгдэж, тус компанийн инженер нь өөр ажилд давхар ажиллаж байгаа гэсэн шалтгаанаар "Сүхжин" ХХК-аас татгалзаж, "Дорнын оч" ХХК-г сонгож, дахин энэ талаар гомдол гараагүй байна.

Мөн Хэрлэн сумын 4-р багт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилгын ажлын тендер оролцсон "Чандмань тал" ХХК-иас тендерийг хэт өндөр үнийн санал ирүүлсэн компанийг шалгаруулсан үндэслэлээр Шүүхэд хандаж, Улсын Дээд шүүхээс үнэлгээний хорооны сонгон шалгаруулалт хууль, журмын дагуу зохион байгуулагдсан гэж үзсэн байна. "Чандмань тал" ХХК-иас шүүхийн шийдвэр хуулийн дагуу явагдаагүй гэж үзэн дараагийн хууль, хяналтын байгууллагад дахин хандахаа илэрхийлээд байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь худалдан авах ажиллагааны 2018 оны жилийн эцэс болон хагас жилийн тайланг хугацаанд нь гаргаж, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тус тус хүргүүлсэн байна.

Б.2. Гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй тохиолдлууд гарсан байна.

Бид аудитын явцад төсөл, арга хэмжээнүүдийн захиалагч, зохиогчийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал, чанарын байдлын талаар газар дээр нь үзэж танилцсан бөгөөд зөрчилтэй болон ашиглагч байгууллагын зүгээс санал, гомдолтой зүйл гараагүй болно.

Харин "Сургуулийн барилга засвар /Дорнод, Хэрлэн 1 дүгээр сургууль/"-ын ажлыг гүйцэтгэсэн "Дөшийн нуруу" ХХК нь гэрээний хугацаанаас 5 хоног, "Чулуунхороот сумын эрүүл мэндийн төвийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрх"-ийг гүйцэтгэсэн "Донж-Өргөө" ХХК нь гэрээний

хугацаанаас 4 хоног хэтрүүлж улсын комисст хүлээлгэж өгсөн байна.

Гэрээний хугацаанаас хоцорч төсөл, арга хэмжээг хүлээлгэн өгсөн “Донж өргөө” ХХК, “Дөшийн нуруу” ХХК-иудаас алдангийн төлбөр болох нийт 317,3 мянган төгрөгийг санхүүжилтийн явцад суутган авсан байна.

Гүйцэтгэгч компаниуд нь захиалагч болон зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар өгсөн зөвлөмжийн дагуу ажлын гүйцэтгэлд гарсан зөрчил дутагдлыг арилгаж ажилласан байна.

Гүйцэтгэгч компаниуд тухайн төсөл, арга хэмжээг зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэсэн эсэхэд тулган баталгаажуулалт хийхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудад тухайн зөрчил гараагүй болно.

Б.3. Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн явцад захиалагчийн хяналтыг аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хэрэгжүүлж ажилласан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 9 ажилд хяналтыг хэрэгжүүлснээс 6 ажилд хийсэн техник хяналтын зардлыг шийдвэрлэж, 3 ажилд техник, хяналтын зардал батлагдаагүйгээс олгогдоогүй байна.

Аймгийн ЗДТГ-аас захиалагчийн хяналтын зардалд 32,4 сая төгрөгийг зарцуулснаас Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 19,8 сая төгрөг, захиалагчийн хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэгч инженерийн зардалд 12,6 сая төгрөгийг тус тус олгосон байна. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь захиалагчийн хяналтын зардлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дансанд төвлөрүүлж ажилласан байна.

ГХБХБГ нь захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайланг ТАХ-ний гүйцэтгэл, санхүүжилтийн баримтад тухай бүрд бүрдүүлэлт хийж, баталгаажуулсан бол хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэгч Төрийн бус байгууллагаас 4,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум/-ын ажилд 12,6 сая төгрөгийн хяналтын зардлыг олгосон ч хэрэгжүүлсэн ажлын талаарх тайланг баримтад хавсаргаагүй, шалгалтын явцад ирүүлээгүй. Тайлангийн хэлэлцүүлгийн үед дээрх зөрчил нь холбогдох мэргэжилтнүүдийн хариуцлагаас шалтгаалсан байгаа тул тайлан баталгаажуулахаас өмнө хүргүүлэх хүсэлтийг ТЕЗ-аас тавьж баримтыг ирүүлсэн.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 3320,0 сая төгрөг олгохоос 3268,5 сая төгрөгийг бодит гүйцэтгэлээр нь гүйцэтгэгч байгууллагад олгож, 51,5 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа хэдий ч худалдан авах ажиллагааны үр дүнгийн биелэлтийг холбогдох цахим систем /www.tender.gov.mn/-д оруулсан талаарх мэдээллийг гүйцэтгэл, санхүүжилтийн баримтад хавсаргаж, баримтжуулаагүй нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт,

санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.5.3² дахь заалтад нийцэхгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн судалгааг 2018.04.03-ны өдөр СЯ-нд хүргүүлсэн байна.

Харин Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6.3³ дахь заалтын дагуу улсын төсвөөс орон нутагт эрх нь шилжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүрийн 03-ны дотор тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр заасан ч энэ талаар хангалттай нотлох баримт байхгүй, нөгөө талаас холбогдох яамдаас тайлан, мэдээ авах чиглэл өгсөн эсэх нь тодорхойгүй байна.

Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.

Хөрөнгө оруулалтын үйл явцад ТЕЗ-ийн дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, ЗГ-ын 2015 оны 483 дугаар тогтоолын 5.2.4-д “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих;” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба нь 2018 онд эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх үүргийг хэрэгжүүлээгүй байна.

III Бүлэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

В.1. Тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

Улсын төсвөөс Дорнод аймагт эрх шилжиж ирсэн 10 төсөл, арга хэмжээний 70.0 хувь нь боловсрол, соёл, урлагийн, 20.0 хувь нь эрүүл мэндийн, 10.0 хувь нь бусад салбарт тус тус зориулагдсан байна.

Эдгээрээс төлөвлөсөн зорилтот түвшин бүрэн хангагдаагүй, ашиглагдахгүй байгаа дараах ажил байна. Үүнд:

- Цэцэрлэгийн барилгын халаалтын нэгдсэн шугамд холбох /Дорнод, Хэрлэн, 2 дугаар цэцэрлэг/ 70,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил дуусаж, улсын комисс хүлээн авсан боловч тус газраар дамжиж байгаа 1000 айлын орон сууцны дулааны төв шугам ашиглалтад ороогүйн улмаас ашиглалтгүй байна.

² 4.5. шаардлагуудыг хангаж, байгаа эсэхийг дараах материалыг үндэслэн ажлын 2 хоногийн дотор санхүүжүүлнэ. Үүнд: 4.5.3. Худалдан авах ажиллагааны үр дүнгийн биелэлтийг холбогдох цахим систем /tender.gov.mn/-д оруулсныг нотлох мэдээлэл

³ Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан боловч худалдан авах ажиллагаа нь орон нутагт эрх шилжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг тухай орон нутгийн захиргааны байгууллага сар бүр энэ журмын зургаадугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, дараа сарын 03-ны дотор тухайн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

В.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 29.2-т “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.”, 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэсэн заалтуудын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр ашиг, үр өгөөжийг тооцсоны үндсэн дээр төсвийн төлөвлөлтөд тусгах ёстой.

Аудитын явцад улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдэд үр ашиг, үр өгөөжийг тооцоолсон эсэхэд горим сорилыг хэрэгжүүлэхэд эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, чанарын ахиц дэвшлийг хэмжигдэхүйц байдлаар, тоон үзүүлэлтээр нарийвчлан тооцоолж төлөвлөсөн судалгаа, тайлан, мэдээлэл байхгүй байна.

Тайлант онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна. Өмнөх онуудаас шилжиж ирсэн аймгийн ЗДТГ-ын барилгын зураг төсөв нь 2009 онд хийгдэж 3,2 тэрбум төгрөгөөр батлагдсан ч он дамжин санхүүжилт хойшлогдсоор 2015 онд 2012 оны ЗТБХБС-ын 181-р тушаалаар батлагдсан “барилгын норм ба дүрэм” –ийн дагуу төсвийг шинэчлэн магадлал хийлгэснээр төсөвт өртөгт өөрчлөлт орж 6,5 тэрбум төгрөгөөр батлагдаж, он дамжин санхүүжилт хойшлогдсоор ашиглалтад ороогүй байна.

Тус барилгад ямар ажил хийгдсэн талаар горим сорилыг хэрэгжүүлэхэд гадна дулаан, цэвэр, бохирын усны шугамын угсралтын болон цахилгааны ажлууд, дотор шавардлагааны ажлууд хийгдэж дууссан байна. Тайлант онд барилгын ажилд 627,0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн захиргааны байгууллагаас олгосон байна. Гэтэл гэрээний дагуу 2018 онд барилгын ажлыг бүрэн дуусгах ёстой байтал гүйцэтгэгч компаниас өмнөх жилүүдийн валютын ханшийн зөрүү, зураг төсөвт тусгагдаагүй ажлуудын нийт 1,3 тэрбум төгрөгийг төсөвт оруулан шийдвэрлэж өгөх тухай албан бичгийг аймгийн ЗДТГ-т хүргүүлсэнтэй холбоотойгоор ажил дуусаагүй байна.

Өмнөх оны “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн 2 зөвлөмжөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд: 2017 онд баригдсан 320,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Зүүн бүсийн ахмад настны асрамжийн төвийн барилгыг тухайн онд ашиглалтад оруулах байтал барилгын гадна инженерийн шугамын угсралтын ажил хийгдээгүйгээс одоог болтол ашиглагдахгүй хэвээр байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээ төсөвт тусгагдан батлагдаж байна.
2. Эрх шилжүүлсэн ТАХ-г хуулийн хугацаа хоцроож шилжүүлсэн байна.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүйгээс тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.
5. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчил давтагдан гарсан байна.

Аудитаар нийт 8107,5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 390,0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 албан шаардлага, 7197,5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, 520,0 зөрчилд 1 санал өгч ажиллалаа.



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, Факс: 7058-4584

2019.04.08 № 4045

танил -ны № -т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Гүйцэтгэлийн аудитын тайланд
хариу хүргүүлэх тухай

Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд Дорнод аймагт хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлттэй танилцаж дараах тайлбар, хариуг хүргүүлж байна.

- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгыг халаалтын нэгдсэн шугамд холбох ажил 70.0 сая төгрөгийн өртгөөр хийгдсэн бөгөөд одоогоор 1000 айлын орон сууцны хорооллын гадна шугам сүлжээний угсралтын ажил бүрэн дуусч, ашиглалтад ороогүйтэй холбоотой ашиглагдахгүй байна. Тус орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг энэ оны 04 дүгээр сард эхлүүлж, 08 дугаар сарын 01-нд бүрэн дуусгаж, ашиглалтад оруулахаар төлөвлөн Захиалагч Барилга, хот байгуулалтын яам, гүйцэтгэгч "Эй Жи Зэт" ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний хугацааг сунган ажиллаж байна.
- Зүүн бүсийн ахмад настны асрамжийн төвийн барилга 2017-2018 онд нийт 392.6 сая төгрөгөөр баригдсан бөгөөд гадна шугам сүлжээний ажил зураг төсөвт тусгагдаагүй учир 2018 онд ашиглалтад орж чадаагүй. Харин 2019 оны улсын төсөвт барилгын шугам сүлжээний ажилд 161.0 сая төгрөг батлагдсан тул энэ онд ашиглалтад орох болно.

Улсын төсвийн хөрөнгөөр Дорнод аймагт 2018 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН



010519213

САНАЛ

Үндэсний аудитын газарт:

1. Холбогдох яам, сайдын багцаас орон нутагт эрх шилжүүлэх төсөл, арга хэмжээг хуулийн хугацаанд шилжүүлж байх талаар ТЕЗ-дад уламжлах

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг хүргүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасны дагуу тооцоо, судалгаанд үндэслэх.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн төсөл, арга хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.
3. Хөрөнгө оруулалтын үр нөлөөг бодитой тооцож төлөвлөж байх.

Аудитаар тавигдсан албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 10

Мөйбөлгөөг хатуу

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар тавигдсан албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнх-Очир, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

110219019

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2019 оны 04 дүгээр
сарын 10-ны өдрийн /10/ тоот тушаалын хавсралт



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн
1	Аймгийн ЗДТГ	ГАГ-2019/01-ГА	Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах тухай	390,000.00
Нийт дүн				390,000.00